



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар A/06

Бор-Өндөр сум

**Газар өмчлөх эрхийн гэрчилгээ бүхий  
нэгж талбарыг нэгтгэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, ЗАХИРАМЖЛАХ нь

1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1.1 дэх заалтын дагуу Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчлөх эрхийн гэрчилгээ бүхий өөрийн 2 нэгж талбарын газрын хэмжээг нэгтгэх хүсэлт гаргасан иргэний газрыг нэгдүгээр хавсралтад заасны дагуу нэгтгэсүгэй.

2. Газар өмчлөх эрхийн гэрчилгээг захирамжаар зөвшөөрөгдөж, нэгтгэгдсэн газрын мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэхийг Газрын даамал /Т.Эрдэнэзаяа/-д даалгасугай.

3. Өмчлөлийн газраа нэгтгүүлсэн иргэнд хууль, тогтоомжид заасан үүргээ чандлан биелүүлэхийг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2026 оны ...01 сарын 09 өдрийн АИОС тоот захирамжийн Нэгдүгээр хавсралт

УХА0001

Газар өмчлөгч болон газрын мэдээлэл

Газар өмчлөгчийн овог, нэр	Регистр	Нэгтгэгдэж буй нэгж талбарын				Нэгтгэгдсэн нэгж талбарын газрын	
		Байршил	Нэгж талбарын дугаар	Хэмжээ	Хэмжээ	Зориулалт	
Адууч Отгонтуяа Бадамсэрээжид	ОЮ02291337	3-р баг Бор-Өндөр, Бумбат говь-13 гудамж, 1310а ТООТ	2322003971	30	730	Гэр бүлийн хэрэгцээ	
		3-р баг Бор-Өндөр, Бумбат говь-13 гудамж, 1312 ТООТ	2322003108	700			